

ДЭЭВЭР ЗАСВАРЫН АЖИЛ  
(5,12,34 ХОРОО)-ЫН ДААЛГАВАР

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 24/53

Улаанбаатар хот

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоол</li> <li>- Баянгол дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/16 дугаар захирамж</li> </ul>
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	<ol style="list-style-type: none"> <li>1. БГД, 5 дугаар хороо "Тэмүүлэл хотхон" 102 дугаар байр</li> <li>2. БГД, 5 дугаар хороо 119 дүгээр байр</li> <li>3. БГД, 12 дугаар хороо 24 байрны 2,3,4 дүгээр орц</li> <li>4. БГД, 12 дугаар хороо 25 байрны 3 дугаар орц</li> <li>5. БГД, 34 дүгээр хороо 56 байрны 2 орц</li> <li>6. БГД, 34 дүгээр хороо 19 байрны 2,3 дугаар орц</li> <li>7. БГД, 34 дүгээр хороо 20 байрны 3,4 дүгээр орц</li> </ol>
3	Зориулалт	- Дээвэр засвар
4	Ажил гүйцэтгэх үе шат, хугацаа	<p>2 үе шаттай.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Дээврийн засварын хэмжилтийн ажлын зураг боловсруулж төсөвт магадлал хийлгэх.</li> <li>2. Дээвэр засварын ажил гүйцэтгэж, хүлээлгэж өгөх.</li> </ol> <p>Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.</p>
5	Ажил гүйцэтгэх байгууллага	Холбогдох тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага.
6	Захиалагч байгууллага	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
7	Төслийн иж бүрдэл	<p>Ажлын зураг Төсөв Магадлалын ерөнхий дүгнэлт Бусад холбогдох материал</p>
8	Онцгой нөхцөл	- Мембран материал байх
9	Ажил гүйцэтгэхэд ашиглах материал	<p><u>Хууль тогтоомжууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын тухай Монгол улсын хууль</li> </ul> <p><u>Норм, дүрэм:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дээврийн ажил БНБД 31-07-05</li> <li>- Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгаалалтын үлгэрчилсэн заавар БД 12-101-05</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНБД 21.02.02/, /БНБД 21.01.02/</li> </ul> <p><u>Стандартууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дээвэр болон ус тусгаарлалтын PVC мембран. Техникийн ерөнхий шаардлага MNS 6303-2011</li> <li>- Ус үл нэвтрүүлэх хуйлмал материал ТУ 5774-002-13157918-95</li> <li>- Гөлмөн төмөр MNS 3154-1984</li> <li>- Уур ус тусгаарлагч материал UCS1503C</li> </ul>

10	Ерөнхий шаардлага	<p><b>Аюулгүй байдал хангах ажил:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажил эхлэхээс өмнө Сууц өмчлөгчдийн холбоо, иргэд, оршин суугчдад мэдэгдэл өгөх, ажлын дараалал, гүйцэтгэх хугацааг тодорхой болгож мэдээллийн самбар байршуулна.</li> <li>- Иргэд, оршин суугчдын явган болон авто машин зорчих хэсгийн аюулгүй байдлыг хангаж, таних тэмдэг байршуулна.</li> </ul> <p><b>Дээвэр хуулж, буулгаж тээвэрлэх ажил:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дээвэр дээрх холбооны болон цахилгааны утас цэгцэлж ажил хийхэд саадгүй болгоно.</li> <li>- Дээврийн хар цаасыг бүрэн хуулж гарсан хог, хаягдлыг цэвэрлэж, буулгах бөгөөд ажил эхлүүлэх бэлтгэл хангана.</li> <li>- Ажил гүйцэтгэхээс өмнө дээврийн хог, хаягдлыг зориулалтын шат ашиглан буулгаж дор бүр нь тээвэрлэнэ.</li> </ul> <p><b>Бохирын болон агааржуулах хоолойн засварын ажил:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Агааржуулалтын хоолой тоосгон өрлөг хийцтэй бол нурсан хэсгийг буулгаж нөхөн сэргээлт хийнэ.</li> <li>- Агааржуулалтын бетон тавцанг шинээр солино.</li> <li>- Эвдэрч гэмтсэн, шаардлага хангахгүй байгаа бохирын яндан хоолойг шинээр солих, зориулалтын агааржуулалтын малгайвч төмөр хийнэ.</li> <li>- Үерийн ус зайлуулах хоолойн хог, лаг, шавар цэвэрлэж хамгаалалтын төмөр тор хийх бөгөөд шаардлагатай бол ус зайлуулах хоолойг шинээр солих буюу засварлана.</li> </ul> <p><b>Бетон зуурмагийн ажил:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хар цаасан дээвэр хуулсны дараа борооны усны уналтын налууг тооцоолж 50-150 мм зузаантайгаар бетон зуурмагаар цутгаж хийнэ.</li> <li>- Бетон зуурмагийн ажлыг зориулалтын помп машинаар цутгана.</li> <li>- Цутгалт хийхдээ парапетны ханаруу нугалаа үүсгэхгүй байхаар тооцоолж уналтын налууг гаргана.</li> <li>- Бетонон зуурмагны марк нь М180-аас багагүй байна.</li> </ul> <p><b>Дээврийн хуйлмал материалын ажил:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Праймер буюу суурь түрхлэгийн ажлыг технологийн дагуу хөрсжүүлэлт хийнэ.</li> <li>- Хар цаасыг чулуугүй нэг үе, чулуутай нэг үе нийт хоёр үе наах ба хамгийн сайн чанартай хуйлмал материал сонгоно.</li> <li>- Хуйлмал материалыг парапетны ханаруу цоройтгон стандартын дагуу наах ба хуйлмал материалын эрмэгийг 2мм-ээс багагүй зузаантай зориулалтын ирмэг дарагч төмрөөр даруулан хадна. Хадаас буюу шүрүүпны алхмын хэмжээ 30 см тутамд нэг байна.</li> <li>- Дээвэрт геотекстиль дэвсэх</li> <li>- Дээвэрт PVC мембран (АНУ-тай дүйцэх) дэвсэх парпедыг бүрэн бүрхэнэ, хуйлмал материалын зөрлөг 10см-ээс багагүй байх</li> <li>- Тагт, агааржуулагчийн дээвэрт 1 үе ус тусгаарлагч уян резин материал дэвсэх</li> <li>- Хуйлмал материалыг парапетны ханаруу цоройтгон стандартын дагуу наана.</li> <li>- Хуйлмал материалыг 100мм-ээс багагүй зөрүүлэг хийж нааж өгнө.</li> <li>- Хар цаасан болон мембран хуйлмал материалын аль нэгийг захиалагч, ашиглагч байгууллагуудтай зөвшилцөн сонгоно.</li> </ul> <p><b>Парапетны засвар, шинэчлэлийн ажил:</b></p>
----	-------------------	---

		<ul style="list-style-type: none"> <li>- Парапетны төмөр сэргээн засварлах, шаардлагатай бол шинээр солино.</li> <li>- Парапет хана нурсан, эвдэрсэн бол шаардлагатай нөхөн сэргээх өрлөг, шавар хийж засварлана.</li> <li>- Байгалийн давагдашгүй хүчин зүйл болох /хуй салхи, аадар бороо/ хийсэхгүй, ус орохгүй байхаар тооцоолж парaped төмрийг хоёр талаас нь хадаж бэхэлгээ хийж өгнө.</li> </ul> <p><u>Дээврийн борооны ус зайлуулах шугамын ажил:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ус тусгаарлах, хөрсжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхдээ ус тусгаарлах тухайн материалын угсралтын технологийн дагуу гүйцэтгэнэ.</li> <li>- Борооны ус зайлуулах шугам хоолойг цэвэрлэж, хог хаягдлаас хамгаалах шүүр, таг тавьж өгнө. Шаардлагатай бол шинээр хийнэ.</li> </ul> <p>Цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан ажлын төлөвлөгөө, график гарган иргэд, оршин суугчдад хохирол учруулалгүй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага ханган ажиллана.</p>
11	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.</li> </ul>

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН  
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.ЭНХЦЭНГЭЛ


ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Г.МӨНХ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Г.НЯМСҮРЭН